ДУНДГОВЬ АЙМАГ
**ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 01 өдөр  Дугаар Б/08  Хажуу шинэ ус

Н.Болор-Эрдэнэд Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3, Засгийн газрын 2022 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газар нь 2020 оноос хойш нийгмийн бодлогын мэргэжилтэн байхгүй байгаа тул Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн Насанбатын Болор-Эрдэнийг нийгмийн бодлогын мэргэжилтнээр 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс түр орлон гүйцэтгүүлэхээр томилсугай.

2.Н.Болор-Эрдэнэ-д Засгийн газрын 2022 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу ТЗ-9 дахь шатлал 791,532.00 (Долоон зуун ерэн нэгэн мянга таван зуун гучин хоёр ) төгрөгийн 40% болох 316,600.00 (Гурван зуун арван зургаан мянга зургаан зуу) төгрөгөөр цалинжуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (У.Сүнжидмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Албан үүргээ гүйцэтгэхдээ Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хориглолт хязгаарлалтуудыг баримтлан, бусад хууль тогтоомж, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэж эрхэлсэн ажилдаа хариуцлагатай хандан, төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахин ажиллахыг (Н.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ӨЛЗИЙТОГТОХ

ТТН6569 9033572

482305008